



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Г Хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор Г
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалт нэмсүгэй:

1/ 2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалт:

“Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь өөр ХААБ-ийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч биш байх.”.

2. Мөн журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтын “этгээд” гэсний дараа “байх ба ХАА-н Биржийн байнгын гишүүнээр зөвхөн ХААБ” гэж, 2 дугаар зүйлийн 2.6.2 дахь заалтын “брокерууд” гэсний дараа “болон дотоод хяналтын ажилтан” гэж, “ХААБ-д” гэсний дараа “болон үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагад” гэж тус тус нэмсүгэй.

3. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000273